

**УЛСЫН ХЭМЖЭЭНД 2017-2021 ОНД ОНЦГОЙ АЖИЛЛАГААНЫ ЖУРМААР
ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ХЭРГИЙН ТОЙМ**
(судалгааны ажлын хураангуй мэдээлэл)

**Нэг. Анхан шатны шүүхээс онцгой ажиллагааны журмаар хянан
шийдвэрлэдэг хэргийн төрөл**

Иргэн, хуулийн этгээдээс дор дурдсан асуудлаар шүүхэд хүсэлт гаргасан бол шүүхээс хэргийг онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэдэг. Үүнд:

- Эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоох; (133.1.1, 135.2.1-135.2.14)
- Хүнийг сураггүй алга болсонд тооцох буюу нас барсан гэж зарлах; (133.1.2)
- Сэтгэцийн өвчний улмаас хүнийг эрх зүйн чадамжгүй болон мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис, согтууруулах ундаа байнга хэрэглэдгийн улмаас хязгаарлагдмал чадамжтай гэж тооцох; (133.1.3)
- Хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцох; (133.1.4)
- Асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосныг хүчингүйд тооцох; (133.1.5)
- Эрх олгосон бичиг баримтыг үрэгдүүлснээс алдагдсан эрхийг сэргээх; (133.1.6)
- Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд буруу бичигдсэнийг тодорхойлох; (133.1.7)
- Иргэний хэргийн буюу шийдвэр гүйцэтгэлийн үрэгдсэн материалыг сэргээх; (133.1.8)
- Нэхэмжлэгчээс гаргасан хүсэлтийн дагуу хариуцагчийг эрэн сурвалжлах; (133.1.9)
- Хуулийн этгээдийг дампуурсанд тооцох (133.1.10) зэрэг болно.

Дээрх асуудлууд нь шүүхэд хүсэлт гаргасан этгээдэд “ач холбогдол бүхий эрх зүйн үр дагавартай” байдаг бөгөөд эдгээр нөхцөл байдлыг шүүхээс тогтоох үед маргалдагч тал байдаггүй онцлогтой.

**Хоёр. Анхан шатны шүүхээс онцгой ажиллагааны журмаар хянан
шийдвэрлэсэн хэргийн тоон мэдээ**


Улсын хэмжээнд Иргэний хэргийн анхан шатны шүүх 2017-2021 онд онцгой ажиллагааны журмаар нийт **51133** хэргийг хянан шийдвэрлэснээс нийслэлийн 9 дүүргийн шүүх **8083** хэрэг буюу 15.8 хувийг, орон нутгийн шүүхүүд **43050** хэрэг буюу нийт шийдсэн хэргийн 84.2 хувийг эзэлж байна.

Хүснэгт 1. Нийслэлийн 9 дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхээс онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэсэн хэргийн дэлгэрэнгүй тоон үзүүлэлт.

Д/д	Хуулийн заалтаар	Он						
		2017	2018	2019	2020	2021	Нийт	Хувь
1	133.1			15			15	0.2
2	133.1.1	63	13	58	93	25	252	3.1
3	133.1.2	6	2	4	6	7	25	0.3
4	133.1.3	4		4	1		9	0.1
5	133.1.4, 145.6	32	40	36	31	34	173	2.1
6	133.1.5	1					1	0.01
7	133.1.9	201	290	246	144	21	902	11.2
8	133.2.1		2	1			3	0.03
9	135.2			1	3		4	0.04
10	135.2.1	11	11	37	48	16	123	1.5
11	135.2.2	4	2	23	39	26	94	1.2
12	135.2.3	1	6	9	8	2	26	0.3
13	135.2.4	120	109	115	114	112	570	7.1
14	135.2.5	1				2	3	0.03
15	135.2.6	736	863	868	987	913	4367	54.0
16	135.2.7	19	12	139	75	54	299	3.7
17	135.2.8	1					1	0.01
18	135.2.10	21	25	26	7	12	91	1.1
19	135.2.12	2			1		3	0.03
20	135.2.13	21	23	31	25	12	112	1.4
21	135.2.14	174	185	175	190	227	951	11.8
22	135.3	3	2	1	2		8	0.1
23	143.1	5	9	19	7	11	51	0.6
Нийт		1426	1594	1808	1780	1474	8083	100%
Хувь		17.6	19.7	22.4	22.1	18.2	100%	


Нэгдүгээр хүснэгтээс үзэхэд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 133 дугаар зүйлийн 133.1.1-133.1.6, 135 дугаар зүйлийн 135.2.1-135.2.14 дэх хэсэгт заасан үндэслэлээр шийдвэрлэсэн хэрэг 2019 онд бусад оноос өндөр үзүүлэлттэй байна.

Бүдүүвч 1. Нийслэлийн 9 дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхээс онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэсэн хэргийн өсөлт, бууралтын хувь



Нийслэлийн 9 дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхээс онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэсэн хэргийн **4367** (54.02 хувь) нь “хүний ажиллаж байсан байдал”-ыг тогтоохтой холбоотой байна (бүдүүвч 2).

Бүдүүвч 2. Нийслэлийн анхан шатны шүүхүүдийн онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэсэн маргааны төрөл




Хүснэгт 2. Орон нутгийн буюу сум, сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхээс онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэсэн хэргийн дэлгэрэнгүй тоон үзүүлэлт.

Д/д	Хуулийн зүйл заалт	Огноо						
		2017	2018	2019	2020	2021	Нийт	Хувь
1	133.1.1	2	4	28	177	6	217	0.5
2	133.1.2	10	4	3	2	3	22	0.05
3	133.1.3	1	1	1	1		4	0.01
4	133.1.4, 145.6	75	42	56	49	33	255	0.6
5	133.1.5					1	1	0.002
6	133.1.6	2			1		3	0.01
7	133.1.9	133	181	262	254	199	1029	2.4
8	133.1.7				1		1	0.002
9	135.2			1			1	0.002
10	135.2.1	14	11	69	62	19	175	0.4
11	135.2.2	20	10	1	6	11	48	0.1
12	135.2.3	45	35	28	29	17	154	0.4
13	135.2.4	425	331	327	420	387	1890	4.4
14	135.2.5	2	1	1		3	7	0.02
15	135.2.6	5602	9389	5950	9854	5295	36090	83.8
16	135.2.7	30	15	76	86	55	262	0.6
17	135.2.8	1	1	1	2	5	10	0.02
18	135.2.9	1				1	2	0.005
19	135.2.10	5	4	5	3	2	19	0.04
20	135.2.11		0	1			1	0.002
21	135.2.12	4	1	2	4	4	15	0.03
22	135.2.13	126	67	68	48	49	358	0.8
23	135.2.14	206	380	380	710	792	2468	5.7
24	135.3		1	3	6		10	0.02
25	135.2.15		7	1			8	0.02
Нийт		6704	10485	7264	11716	6882	43050	100%
Хувь		15.6	24.3	16.9	27.2	16.0	100%	

Хоёрдугаар хүснэгтээс харахад Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 133 дугаар зүйлийн 133.1.1-133.1.6, 135 дугаар зүйлийн 135.2.1-135.2.14 дэх хэсэгт тус тус заасан үндэслэлээр шийдвэрлэсэн хэрэг 2020 онд бусад оноос өндөр үзүүлэлттэй байна.

Бүдүүвч 3. Сум, сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхээс онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэсэн хэргийн өсөлт, бууралтын хувь



Иргэний хэргийн анхан шатны шүүхээс онцгой ажиллагааны журмаар 2017-2021 онд хянан шийдвэрлэсэн **нийт 51133** хэргээс хамгийн их буюу 40457 хэрэг (**79.1 хувь**) -ийг Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 135 дугаар зүйлийн 135.2.6 дахь хэсэгт заасан “ажиллаж байсан байдал тогтоолгох” хүсэлт бүхий хэрэг эзэлж байна.